



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 12 сарын 03 өдөр

Дугаар A/492

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/ -д тус тус үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн сайдын 2018 оны  
 12 дугаар сарын 03 - ны өдрийн  
 А/492 дугаар тушаалын хавсралт



**Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын нэрс**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Н.Гэндэнжамцын нэрэмжит Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	291/2018	5 жил	2018-12-01	2023-12-01
2.	Баян-Өлгий аймгийн "Сансар" эмнэлэг	292/2018	4 жил	2018-11-30	2022-11-30
3.	Нийслэлийн "Хүрээ" амаржих газар	293/2018	2 жил	2018-11-30	2020-11-30
4.	"Найман-Очир" ХХК-ний "Чимэг" эмнэлэг	294/2018	2 жил	2018-11-30	2020-11-30
5.	Сүхбаатар дүүргийн "Түвшин хүч" өрхийн эрүүл мэндийн төв	295/2018	1 жил	2018-11-30	2019-11-30
6.	"Бүүргэнт" ХХК-ний "Ариун лотус" сувилал	296/2018	2 жил	2018-12-27	2020-12-27
7.	Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	297/2018	3 жил	2018-09-13	2021-09-13
8.	Өмнөговь аймгийн Ханбогд сумын сум дундын эмнэлэг	298/2018	2 жил	2018-07-08	2020-07-08
9.	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын эрүүл мэндийн төв	299/2018	2 жил	2018-07-08	2020-07-08
10.	Өмнөговь аймгийн Сэврээ сумын эрүүл мэндийн төв	300/2018	4 жил	2018-07-08	2022-07-08
11.	Өмнөговь аймгийн "Шимбилэг" өрхийн эрүүл мэндийн төв	301/2018	2 жил	2018-11-30	2020-11-30
12.	Өмнөговь аймгийн "Энхийн хүслэн" өрхийн эрүүл мэндийн төв	302/2018	2 жил	2018-11-30	2020-11-30
13.	Өмнөговь аймгийн "Энэрэхүй-Ухаан" өрхийн эрүүл мэндийн төв	303/2018	1 жил	2018-11-30	2019-11-30
14.	Өмнөговь аймгийн "Илбийн говь" ХХК-ний "Амуу" эмнэлгийн харьяа "Ар Үр" сувилал	304/2018	2 жил	2018-11-30	2020-11-30